


ХУУЛЬ САХИУЛАХ САЛБАРЫН ИННОВАЦИ

LAW ENFORCEMENT INNOVATION



Хууль сахиулах салбарын инноваци

**А.БАТСАЙХАН**

Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан

BATSAIKHAN A.

Research Assistant at the Research and Development Institute of the Law Enforcement University of Mongolia

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд Монгол Улс өөрийн шинжлэх ухаан болон техник технологийн суурь үндсийг бэхжүүлэхээр маш их оролдож байна. Төрийн бодлого үндсээрээ шинжлэх ухааны үндсэн байгууламжууд болон инновацийн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэж, “инноваци” гэх зэрэг нэр томъёо олон нийтийн дунд маш хурдан тархаж, үр дүнд нь хууль сахиулах салбар хүртэл тухайн ойлголтыг өөрийн хэмжээнд бий болгох гэж зүтгэж байгаа билээ. Гэвч, яг хууль сахиулах салбарын инноваци гэдэг ойлголт, түүний учир шалтгаан, үйл явц болон үр дүнтэй холбоотой тодорхой тайлбар хийсэн явдал одоохондоо хараахан байхгүй. Энэ нь чухам эрдмийн талбарт маш том хоосон орон зайг бий болгож байгаа юм.

Тиймээс, энэ өгүүлээр хууль сахиулах салбарын инновацийн тухай ерөнхий ойлголтуудыг “хүний зан авирт технологи гэдэг зүйл хэрхэн нөлөөлдөг болохыг тайлбарлах; хууль сахиулах салбар болон шинжлэх ухаан хоёр хоорондоо хэрхэн уялддаг болохыг тодорхойлох; Монгол, Америкийн хувийн аюулгүй байдлын салбар болон цэргийн аж үйлдвэрийн цогцолборуудыг харьцуулан судлах; хууль сахиулах салбарын технологийн ба үйл ажиллагааны инноваци гэдэг ойлголтуудыг тодорхойлох; Монгол Улс дахь инновацийн дэд бүтцийг яагаад хөгжүүлэх шаардлагатай болохыг тайлбарлах” замаар тодорхойлох гэж оролдлоо.

Abstract: Over the last few years the Mongolian government has been attempting to rebuild the scientific and technological foundations of the country. Government policies have shifted focus towards the scientific establishment and innovation infrastructure. The term “innovation” has become a popu-

lar concept amongst the public and recently the law enforcement sector has boarded this bandwagon. However, the concepts related to innovation in the law enforcement sector, its causes, processes and outcomes do not seem to be well-defined. As a result, the intellectual arena is left with a vacuum.

Accordingly, this article aims to provide a general understanding about the concept of innovation in the law enforcement sector through explanations of the effect of technology on human behaviour; the relationship between the law enforcement sector and science; historical narratives on the American and Mongolian private security industries and military industrial complexes; the concept of technological and operational police innovation; as well as the necessity of developing the law enforcement innovation infrastructure in Mongolia.

Түлхүүр үгс: шинжлэх ухаан, технологи, гэмт зан үйл/гаж зан үйл, хууль сахиулах салбар, салбар шинжлэх ухаан, хувийн аюулгүй байдлын салбар, хувийн аюулгүй байдлын аж үйлдвэр, цэргийн аж үйлдвэрийн цогцолбор, инновацийн дэд бүтэц, гэмт хэргийг тогтоон хязгаарлах, технологийн инноваци, үйл ажиллагааны инноваци, орон нутгийн/олон нийтийн цагдан сэргийлэлт, стратегийн цагдан сэргийлэлт, асуудалд тулгуурласан цагдан сэргийлэлт.

Keywords: science, technology, law enforcement, criminal/deviant behaviour, law enforcement sector, sub-branch, discipline of science, private security sector, private security industry, military industrial complex, innovation infrastructure, deterrence of crime, police innovation, technological innovation, operational innovation, community policing, strategic policing, problem-oriented policing.

I. Оршил

Ихэнх хүн өнөөдрийн амьдралыг орчин үеийн технологигүйгээр төсөөлж чадахгүй байх. Шинжлэх ухаан болон технологи хүний амьдралын хэв маягийг асар их сайжруулсан нь бодит үнэн бөгөөд цаашид ч улам сайжруулсаар байх болно. Түүхээс харахад хүн төрөлхтний хамгийн том бэлэг бол өөрийн оюун ухааныг ашиглан амьд явах магадлалыг нэмэгдүүлж, зарим нэг тодорхой төрлийн ажил үүргийг хөнгөвчлөх юм. Гэвч, нэг хүний оюун ухаанаар бүтээсэн эд хэрэгслийг нөгөө нь буруугаар ашиглаж, хорон үйлдэлд хэрэглэж болдгийг бас ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хүн гэдэг амьтан оршин тогтнож байгаа цагт шинжлэх ухаан, технологийн дэвшлийг үргэлж сайн сайхны төлөө ашиглана гэж байхгүй. Криминологийн зарим нэг онол хүнийг ямар нэг байдлаар нийгмийн хяналтад аваагүй тохиолдолд, тэр хууль дүрэм болон нийт нийгмийн сайн сайханд нийцээгүй гаж зан үйл гаргах илүү өндөр магадлалтай байдаг гэж үздэг¹.

Энэ утгаараа, хүний амьдрал шинжлэх ухаан, технологиос улам хамааралтай болж байгаа энэ үед гэмт хэрэгтнүүд ч техник технологийн дэвшлийг ашиглан гэмт үйлд ашиглах нь гарцаагүй үр дагавар билээ. Энэ өгүүлэл хууль сахиулах салбарт шинжлэх ухаан, технологи хэрхэн нөлөөлж, түүний үйл ажиллагаа болон дэд бүтцийг авч үзэхээс гадна, хууль сахиулах салбарын инновацийн төрлүүдийг тодорхойлж, мөн шинэ инноваци нийгмийн сайн сайханд ямар үр өгөөжтэй байлан болохыг тайлбарлах болно.

II. Хууль сахиулах салбар дахь шинжлэх ухаан болон технологи – өөрчлөгдөж буй орчин

Шинжлэх ухаан болон технологийн дэвшил энэ орчлонд маш олон сайн сайхан зүйлсийг авчирсан ба дэлхийн даяаршил бол түүний үр дүнд гарсан шууд өөрчлөлт. Гэвч, бусад бүх процессын адил, дэлхий дахин ингэж хурдан өөрчлөгдөж байгаа явдал эерэг ба сөрөг талтай. Дэлхийн даяаршлаас болж үүссэн нэг сөрөг тал нь үндэстэн дамнасан гэмт хэрэг болон алан хядах үйл ажиллагааны огцом өсөлт байна. “2009 онд НҮБ-ын Хар тамхи, мансуурах бодис ба гэмт хэрэгтэй тэмцэх албанаас үндэстэн дамнасан гэмт хэргийн үйл ажиллагааг ойролцоогоор 870 тэрбум америк доллар буюу дэлхийн ДНБ-ий 1.5%-тай тэнцэж байна гэсэн

тооцоолол гаргасан бол, өнөөдөр жилд 1 их наяд доллартай тэнцэхээр болжээ”². Үндэстэн дамнасан гэмт хэрэг болон алан хядах ажиллагаа чухам яагаад ингэж огцом өсөж байгаа нь дэлхий даяаршиж байгаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, техник технологийн ололт дэвшил урд өмнө хүн төрөлхтний түүхэнд хэзээ ч байгаагүйгээр нэг нэгэнтэйгээ харилцах боломжийг олгосон. Харилцаа холбооны хэрэгсэл сайжирснаар хүмүүс нэг нэгэнтэйгээ шууд холбогдож, харин тээврийн хэрэгсэл сайжирснаар улс орноор аялах, бараа бүтээгдэхүүн тээвэрлэх үйл явц улам эрчимжсэн. Хамгийн гол нь энэ бүх ололт дэвшлийг зөвхөн сайн зорилгод бус, муу зорилгод ч бас хэрэглэх боломжтой.

Хууль бус ажиллагаа явуулах асуудал бол үргэлж хүний өөрийнх нь биологийн онцлог шинж чанарт шингэсэн практик үйлдэл билээ. Байгалийн жам ёсоор, нийгэмд амьдарч байгаа хүмүүс нийтийн сайн сайхныг хангахад зориулж тогтоосон стандарт хэм хэмжээг зөрчиж, улмаар нэг нэгэнтэйгээ хагаралдах учиртай. Үүний шалтгаан нь хүний өөрийнх нь хувийн үзэл бодолтой холбоотой ба хүн нэгэнт хууль зөрчихөөр шийдсэн бол үүнийгээ тодорхой эд хэрэгсэл ашиглан үйлддэг. Энэ нь ерөнхийдөө хүний зан чанар үргэлж өөрчлөгдөж, гэмт хэрэг үйлдэх арга барил улам нарийсаж, мөн үйлдэж буй гэмт хэргийн төрөл үргэлж хувирч байдаг гэсэн үг.

Тухайлбал, компьютер болон интернет сүлжээ хүний амьдралын нэг хэсэг болохоос өмнө кибер буюу цахим гэмт хэрэг гэдэг ойлголт огт байгаагүй бөгөөд тухайн үзэгдэл дээр дурдсан өөрчлөлтийн нэг жишээ билээ. Анх компьютер болон интернет сүлжээг ашиглаж эхлэхэд хэн ч тухайн хэрэгслийг хүний амьдралд ингэж их нөлөөлнө гэдгийг олж хараагүй; тухайн технологийг тийм өргөн ашиглагдана гэдгийг ч төсөөлөөгүй. Харин орчин үед хүмүүс компьютер технологийн үр нөлөөг илүү ойлгож чадсан ба хүний өдөр тутмын ажил, амьдралд хэрхэн нөлөөлдөг болохыг мэднэ, ялангуяа гэмт ажиллагаанд хэрхэн ашиглагдаж болохыг. Компьютер технологи гэдэг зүйл нэгэнт хүний өдөр тутмын амьдралын нэг хэсэг болж хувирсан тул орчин цаг үед гэмт хэрэгтнүүд ч түүнийг ашиглан хохирогчдыг

¹ Роналд Л.Акерс & Кристин С.Селлерс (2009): “Криминологийн онол” (Oxford University Press – 5 дахь хэвлэл; 123 – 148 тал)

² Стивен Д’Алфонсо (04.09.2014): “Яагаад зохион байгуулалттай гэмт хэрэг болон алан хядах бүлгэмүүдийн тоо ихсэж байна вэ?” (Security Intelligence; <https://securityintelligence.com/why-organized-crime-and-terror-groups-are-converging/>; [2017 оны 2 дугаар сарын 6])



Хууль сахиулахуй

онилж байна. “Кибер гэмт хэрэг, голдуу интернет сүлжээгээр дамжуулан үйлдэгддэг. Сүүлийн үед компьютер гэдэг зүйл худалдаа арилжаа, зугаа цэнгэл болон төрийн үйл ажиллагаанд онц ач холбогдолтой болж хувирснаар тийм төрлийн гэмт хэрэг улам газар авч байна”³.

Орчин үед олон улсын хэмжээнд улс төрийн зорилготой хакерын бүлгүүд (ж/нь: Anonymous), бие даасан хакерууд болон компьютерийн суут ухаантнууд засгийн газрын томоохон дата баазуудад хохирол учруулахаар кибер довтолгоо их хэмжээгээр үйлдэж эхэлсэн. “Мэдээлэл олзлогч” буюу “ransom ware” хэмээх програм хангамж тийм довтолгоо гүйцэтгэх хамгийн сүүлийн үеийн арга билээ⁴. Ийм төрлийн шинэ гэмт хэрэг хууль сахиулагчдад урд өмнө огт байгаагүй асуудал бий болгож, түүнтэй тэмцэхийн тулд хууль сахиулах байгууллагын хүний нөөц тухайн салбар ухааны мэргэжилтнийг байгууллагадаа аль болох оруулах асуудалтай тулгарсан. Түүнчлэн, хууль сахиулагчид уламжлалт гэмт хэрэг, зөрчилд давхар анхаарал хандуулж байх үндсэн шаардлагатай. Гол нь тийм төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд маш их хүч хөдөлмөр шаарддаг. Азаар тэдгээр гэмт хэргийн зөрчлийг илрүүлж, ажил хэргийг зохион байгуулах шинэ хэрэгслүүд бий. Хамгийн гол нь тэдгээр хэрэгсэл бүгд шинэ техник технологи дээр суурилсан байдаг.

Энэ утгаараа, хууль сахиулах салбарт тулгамдаж буй шинжлэх ухаан болон технологитой холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийн тулд шинэ технологи болон шинжлэх ухааны хөгжилд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Гэвч, хөрөнгө оруулалт хийхээс өмнө юунд хамгийн түрүүнд хөрөнгө зарцуулах ёстой вэ гэдэг асуултад хариулах нь чухал.

Хууль сахиулах салбар бүхэлдээ хэд хэдэн дэд салбараас бүрдэж байдаг. Харамсалтай нь одоогийн байдлаар ихэнх хүн хууль эрх зүй болон цаазыг хууль сахиулах салбарын хамгийн чухал дэд салбар гэж үздэг бөгөөд зөвхөн тэр ойлголтынхоо хүрээгээр хязгаарладаг. Тэд эндээс юуг харж чаддаггүй вэ гэвэл, хууль сахиулах салбарыг хоорондоо харилцаа хамааралтай байдаг маш олон

шинжлэх ухааны мэдлэгээс бүрддэг гэдгийг харж чаддаггүй. Тухайлбал:

Хууль сахиулагчдын үндсэн үүрэг бол хууль ёсыг дээдэлж, гэмт хэрэгтэй тэмцэх. Тиймээс, хууль эрх зүй болон цааз тухайн ойлголтын гол цөм билээ. Гэвч, хэрвээ бид түүний цөмийг задалж үзвэл шинжлэх ухаан болон технологи маш чухал бүрэлдэхүүн хэсгүүд байдаг болохыг олж харна. Жишээлбэл, хэрэв бид хэв журмын цагдаа нарыг гэмт хэрэгтэй тэмцэх илүү үр дүнтэй хэрэгслээр хангаж өгвөл тэдний ажлын гүйцэтгэл асар өндөр үзүүлэлттэй байна. Нөгөө талаас, хэрвээ бид тэднийг гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнгүй эд хэрэгслээр хангаж өгвөл ажлын гүйцэтгэл нь тун тааруухан үзүүлэлттэй байх жишээтэй. Тийм учраас хууль сахиулах салбар өөрөө өөртөө логикийн дэмжлэг үзүүлж, тодорхой төрлийн үйлчилгээ болон эд хэрэгслийг хангаж өгч байх учиртай. Хамгийн гол нь өөрөө өөртөө логикийн дэмжлэг үзүүлж, тодорхой төрлийн үйлчилгээ болон эд хэрэгслээр хангах асуудал зөвхөн хууль эрх зүй болон цаазаар хязгаарлагдахгүй.

Гэмт хэрэгтэй тэмцэж, хууль зөрчих гаж зан үйлийг таслан зогсоох өөрсдийн үр чадварыг сайжруулах шинэ техник технологи болон шинжлэх ухааны аргачлалыг нээхийн тулд байгаль болон техникийн төрөл бүрийн шинжлэх ухааны мэдлэг эзэмшсэн байх шаардлагатай. Тийм учраас хууль сахиулах салбар маш олон төрлийн шинжлэх ухааны салбар, тухайлбал шинжлэн магадлахуй, инженерчлэл, компьютер технологи, оёдлын ба галт зэвсгийн технологи гэх зэргийг хамруулсан байдаг (энд хэдхэн жишээ дурдав).

Хэрвээ хууль сахиулах салбар дээр дурдсан олон шинжлэх ухааны салбаруудыг үнэхээр хамруулдаг юм бол, алба хаагчдын гэмт хэрэгтэй тэмцэж, хууль зөрчих явдлыг таслан зогсоох үр чадварыг нэмэгдүүлэхийн тулд эдгээр бүх дэд салбарт хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Ялангуяа, шинэ технологи болон инноваци бий болгоход хөрөнгө оруулалт хийх хамгаас чухал. Үүнийг бид одоо болтол ойлгохгүй байх шиг байна. Энэ бүхнээс гадна, бас нэг асуулт бий. Тэр нь “хууль сахиулах салбарын инноваци гэж яг юуг хэлэх юм бэ?” гэдэг асуулт. Хууль сахиулах салбарын инноваци гэдэг нь “гэмт хэрэгтэй тэмцэх шинэ технологийг бий болгох уу?” аль эсхүл “хууль сахиулах үйл ажиллагааг үр дүнтэй болгох шинэ стратегийг боловсруулах уу?” Хариулт бол энгийн, хоёулаа.

³ Майкл Аарон Деннис (Сүүлд шинэчилсэн: 08.08.2016): “Кибер гэмт хэргийн тодорхойлолт” (*Britannica Encyclopedia*; Дараах хаягаас харах боломжтой: <https://www.britannica.com/topic/cyber-crime> [2017 оны 2 дугаар сарын 6])

⁴ Элдон Амороос (2016): “Кибер аюулгүй байдал: Цагдаагийн удирдлагын зүгээс анхаарах хэрэгтэй асуудлууд болон авах хариу арга хэмжээ” (*The Police Chief Magazine* – 2016 оны 10 сар; 28 –33 тал)

III. Хууль сахиулах салбарын инноваци – технологийн болон үйл ажиллагааны инноваци

Та бүхэн “хоёулаа” гэхээр хууль сахиулагчдыг техникийн мэргэжилтнүүд, зохион бүтээгчид болон байгалийн шинжлэх ухааны эрдэмтэд байх шаардлагатай гэж хэлэх гээд байна уу гэж бодож байж магадгүй. Энэ асуултын хувьд би “тийм” бас “үгүй” гэж хариулна. Та бүхэнд сонин санагдаж магадгүй, гэхдээ хэрвээ хууль сахиулагчид үнэхээр техникийн мэргэжилтнүүд, зохион бүтээгчид болон байгалийн шинжлэх ухааны эрдэмтэд байх боломжтой бол сайн хэрэг. Хэрвээ тэд тийм байж чадахгүй бол ядаж л тэдгээр хүмүүстэй хамтран үйл ажиллагаагаа улам сайжруулах арга замыг эрэлхийлж байх хэрэгтэй. Барууны улс орнуудтай харьцуулбал, урд өмнө нь социалист байсан Монгол Улсын хувийн аюулгүй байдлын аж үйлдвэр буурай хөгжилтэй (энд надад социалист байсан гэдгийг тодотгох хэд хэдэн шалтгаан бий; үүнийг та миний бичсэн “Хууль сахиулах салбарын инновацийн дэд бүтцийг чөлөөт зах зээлийн эдийн засгийн нийгэмд хөгжүүлэх нь” сэдэвт өгүүллийг уншина уу)⁵. Хэрвээ бид барууны улс орны төр болон хувийн хэвшлийн түншлэлийн загварыг хувийн аюулгүй байдлын салбарын хэмжээнд авч үзвэл, тэдний засгийн газрууд үнэхээр хувийн компаниудтай нягт холбоотой ажилладаг болох нь харагдана.

Америкийг жишээ болгон авч үзвэл, цагдаагийн бэлтгэл офицерууд техникийн компаниудад зөвлөх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хууль сахиулах үйл ажиллагаанд чухам ямар хэрэгсэл хэрэгтэй байгааг тодруулж өгдөг. Түүнчлэн, АНУ-ын цэргийн аж үйлдвэрийн цогцолбор гэдэг том механизм маш боловсронгуй бөгөөд хууль сахиулах салбартай шууд холбоотой. Энэ том механизмыг чухам батлан хамгаалах төсөвт оруулж буй хөрөнгөөр эргэлдүүлж байдаг бөгөөд Америкийн батлан хамгаалах төсөв дэлхийн хамгийн өндөрт тооцогддог (жилд ойролцоогоор 569 тэр бум доллар)⁶. Батлан хамгаалах салбарт олж нээсэн ямарваа нэг шинэ технологийг цаашид хууль сахиулах салбарт шилжүүлэн төрийн агентлагуудын үйл ажиллагааг сайжруулахад ашигладаг.

⁵ “Хууль сахиулах үйл ажиллагаа (2016): Онол, практикийн тулгамдсан асуудал”. (Хууль сахиулахын их сургууль; Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Боть 2; 475 дахь тал.

⁶ Эйшли Керк (27.10.2015): “Дэлхийн хамгийн том батлан хамгаалах төсөвтэй улсууд юу вэ?”

(The Telegraph; <http://www.telegraph.co.uk/news/uknews/defence/11936179/What-are-the-biggest-defence-budgets-in-the-world.html> [2017 оны 2 дугаар сарын 6])

Хууль сахиулах салбарт логистикийн дэмжлэг үзүүлэх, түүнийг тодорхой төрлийн үйлчилгээ болон эд хэрэгслээр хангах ажлыг тэгэхээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд дангаараа бус, хувийн аж ахуйн нэгжүүдтэй хамт тэдгээртэй гэрээ байгуулах замаар гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, хууль сахиулах болон цэргийн байгууллагуудад гэрээгээр үүрэг гүйцэтгэдэг компаниуд олон байдаг бөгөөд энэ чиг хандлага цаашид улам өсөх төлөвтэй (1990 оноос хойш өсөж байгаа). “Орчин үеийн хувийн цэргийн аж үйлдвэрийн цогцолбор нь 1990-ээд оны эхээс үүдэлтэй бөгөөд гурван хүчин зүйлсээс болж гарч ирсэн билээ. Үүнд: ‘хүйтэн дайны төгсгөл, цэрэг болон энгийн ард түмнийг ялгаж өгөх хязгаарлалт гэдэг зүйл алдагдсанаар бий болсон дайны арга зүйн шилжүүлэлт болон дэлхий даяар засгийн газрын гүйцэтгэх ажил үүргийг гаднын байгууллагуудаар хийлгүүлж, хувьчлах болсон чиг хандлага’ багтана”⁷.

Ерөнхийдөө бол АНУ-д хувийн аюулгүй байдлын салбар болон аж үйлдвэрийн цогцолбор бий болсон явдал тухайн улсын өөрийнх нь хөгжлийн замнал болон гэмт хэргийн үзэгдэлтэй шууд холбоотой. Хувийн аюулгүй байдлын компаниуд анх капитализм мандан бадарч, гэмт хэрэг гэдэг зүйл энгийн үзэгдэл байсан эртний үед бий болсон байдаг. Тэр үед хувийн өмчийг хамгаалах асар их шаардлага байсан боловч, АНУ-ын засгийн газраас боловсруулж өгсөн хууль тогтоомж өмч эзэмшигчдийн эрхийг хангаж өгч чадахгүй байв. Галт тэрэг болон далайн тээврээр илгээсэн ачаа тээш хулгайлагдах магадлал асар өндөр байсан бөгөөд засгийн газрын зүгээс баталж өгсөн хууль тогтоомж тэдний хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байсан цаг үе. Иймээс, галт тэрэгний компаниуд өөрсдийн эд хөрөнгийг хамгаалах үүднээс өөр арга замыг хайж эхэлжээ.

Хувийн аюулгүй байдлын салбарыг бий болгоход тээврийн салбар чухал нөлөө үзүүлсэн байдаг. Хенри Уэллс болон Уильям Г.Фарго нар ‘American Express’ болон ‘Wells Fargo’ компаниудыг анх 1850-аад оны үед худалдааны зориулалттай ачаа тээврийг зүүн болон алс дорнодод хамгаалах үүднээс байгуулсан. ‘Wells Fargo’ компани зэвсэглэсэн хамгаалагчид, төмөр морин тэрэг болон хувийн мөрдөх ажиллагаа явуулдаг байжээ.

⁷ П.В.Сингеп (2005): “Дайныг ацаглах”

(Foreign Relations, 84 дүгээр дэвтэр, Дугаар 2; 120 тал; Дараах хаягаас харах боломжтой: <http://www.jstor.org/stable/20034280> [2017 оны 2 дугаар сарын 6])



Хууль сахиулахуй

Төмөр замын салбар мөн аюулгүй байдлаа хангах зайлшгүй шаардлагатай байв. 19 дүгээр зууны хамгийн өргөн хэрэглэгддэг тээврийн хэрэгслийн хувьд, төмөр зам гэмт хэргийн халдлагад өртөх өндөр эрсдэлтэй байжээ. Иргэний дайн болохоос өмнө төмөр замыг 'Pinkertons' хэмээх нэртэй хувийн мөрдөн байцаах компани хамгаалдаг байсан юм⁸.

Тун удалгүй, хувийн компаниуд гэрээт хамгаалалтын ажилчдыг томилон ашиг олох боломжтой гэдгийг харж эхэлсэн байна. Түүнээс гадна, Америкийн зохион бүтээгчид улам их сэтгэж, зохиож, бүтээж эхэлснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шинэ технологиудыг өргөн хэрэглээнд нэвтрүүлжээ. Жишээлбэл, цахилгаан дохиоллын систем бол эдгээр бүтээлийн нэг⁹. Тухайн цаг үед цахилгаан дохиоллын систем бол шинэ инноваци байв. Ийнхүү систем нь технологийн инноваци байсан бөгөөд технологи гэдэг зүйл гэмт зан үйлийг тогтоон хязгаарлахад хүнээс дутахааргүй чухал.

Сүүлийн үед компьютер болон технологи өргөн хэрэглээнд нэвтэрснээр маш олон төрлийн шинэ цагдаагийн стратегиуд бий болж байна. Хүн төрөлхтний түүхэнд урд өмнө нь хэзээ ч "зөвхөн хурууны үзүүрээ ашиглан нэг доороос хязгааргүй их мэдээлэл авах боломж" байгаагүй. Харамсалтай нь дээр дурдсаны дагуу энэ технологийг мөн гэмт хэрэгтнүүд ашиглах боломжтой юм. Аз таарахад, хууль сахиулагчид мөн тухайн нөөц хэрэгслийг ашиглах бүрэн боломжтой бөгөөд зөв хэрэглэсэн тохиолдолд өөрсдийнхөө гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг асар их нэмэгдүүлж болно.

Тиймээс, шинэ цагдаагийн ажиллагаа бий болгох нь өөрөө хууль сахиулах инновацид тооцогдох юм. Шинжлэх ухаан болон технологийн давуу талыг ашиглан хууль сахиулагчид өөрсдийн дотоодын үйл ажиллагааг сайжруулж, гүйцэтгэлээ нэмэгдүүлэх боломжтой ба энэ нь эргээд ард иргэдэд илүү өндөр үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой. Одоогийн байдлаар гурван төрлийн цагдан сэргийлэх стратеги байдаг. Эдгээрийг судлаачид чухам "олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэлт", "стратегийн цагдан сэргийлэлт" болон "асуудалд тулгуурласан цагдан сэргийлэлт"

гэж нэрлэсэн байдаг (зарим нь үүнээс их гэж хэлж магадгүй). Эдгээр стратеги нь мэдээж хэрэг хоорондоо холбоотой бөгөөд заримдаа давхацсан санаануудыг агуулсан мэт санагдах боловч бас ялгаатай. Шинээр бий болсон стратегиудад нийтлэг нэг шинж чанар байдаг, тэр нь технологийн гүйцэтгэх үүрэг юм. Доорх хэсэгт стратеги бүрийг хураангуйлан тодорхойлсон болно:

1. Олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэлт — 20 дугаар зууны дунд үеэс эхлэн цагдаагийн алба хаагчид гудамжаар алхан эргүүлэн хийхээ больсон байдаг. Үүнээс болж цагдаагийн гүйцэтгэх үүрэг эрс өөрчлөгдсөн. Цагдаагийн алба хаагчид явган эргүүл хийхээ больсноор орон нутгийн ард иргэдтэй харилцахаа больж, үр дүнд нь тухайн орон нутагт тулгамдаж буй яг бодит асуудлуудыг тодруулж чадахаа байсан.

Энэ явдал 1980-аад оныг хүртэл үргэлжилсэн бөгөөд цагдаагийн алба хаагчид автомашинтай эргүүл гүйцэтгэсээр байжээ. Түүнд суурин радио байршуулснаар уг асуудал нь улам хүндэрсэн байна. Харин 1980-аад оны сүүл үеэс зөөврийн радио өргөн хэрэглэж эхэлснээр явган эргүүл хийх нь илүү түгээмэл болов. Хэдийгээр явган эргүүл гэмт хэргийн түвшинг бодитоор бууруулдаг эсэхийг судалгаагаар баталж чадаагүй боловч, ард иргэд цагдаагаас үзүүлж буй үйлчилгээнд илүү сэтгэл өндөр байв. Үүний үндсэн шалтгаан нь цагдаа нар явган эргүүл хийснээр гэмт хэрэгт өртөх айдсыг бууруулсан байна.

Ерөнхийдөө бол 1980-аад оноос хойш олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргийг бууруулах төрөл бүрийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн байдаг. Эдгээр хөтөлбөрүүд нь хөршийн холбоо, залуучуудтай хийх нийгмийн ажил, цагдаагийн алба хаагчид явган эргүүл хийх болон сургуулиудаар цагдаагийн алба хаагчид айлчилж, сургалт зохион байгуулах гэх зэрэг ажлыг хамруулж байжээ. Үүнээс гадна, орон нутгийн ард иргэд өөрсдийн сайн дурын үндсэн дээр цагдаагийн алба хаагчдад туслах төрөл бүрийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь үндсэндээ "олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэлт" гэдэг нэр томъёог бий болгосон байна.

2. Стратегийн цагдан сэргийлэлт — Стратегийн цагдан сэргийлэлт гэдэг нь технологийг зөв зохистой ашигласнаар цагдаагийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийг хэлнэ. Тус ойлголт нь цагдаагийн нөөц хэрэгслийг статистикийн дүн шинжилгээ дээр үндэслэн зөв ашиглаж, хуваарилахыг

⁸ Чарльз Немет (2011): "Хувийн аюулгүй байдлын салбар болон хууль эрх зүй" (*Elsevier*, 4 дахь хэвлэл ; 8 – 9 тал)

⁹ BurglarAlarms.org (2010): "Дохиоллын системийн түүх" (Дараах хаягаас харах боломжтой: <http://www.burglaralarms.org/the-history-of-burglar-alarms/>; [2017 оны 2 дугаар сарын 6])

хэлдэг. Жишээлбэл, газрын зураг дээр гэмт хэрэг гарах магадлалтай хамгийн “халуун цэг”-үүдийг тодорхойлж, тэнд илүү их цагдаагийн эргүүл томилох нь стратегийн цагдан сэргийлэлт юм. Эрдэмтэн судлаачид стратегийн цагдан сэргийлэлтийг янз бүрээр нэрлэдэг. Тухайлбал халуун цэгийн цагдан сэргийлэлт, мэдээлэлд тулгуурласан цагдан сэргийлэлт болон таамаглалт цагдан сэргийлэлт гэх мэтчилэн. Тус цагдаагийн стратегийг хэрэгжүүлэхэд газар зүйн болон хүн ам зүйн дата багц тун чухал.

3. Асуудалд тулгуурласан цагдан сэргийлэлт – Асуудалд тулгуурласан цагдан сэргийлэлт нь алба хаагчдыг илүү идэвхтэй байхыг шаарддаг. Тус стратеги олон нийтэд түшиглэсэн цагдан сэргийлэлттэй шууд холбоотой. Учир нь тэдгээр стратеги нь хоёулаа харилцаж буй хүнийхээ бодит нөхцөл байдлыг мэдэж авахыг шаарддаг. Тус ойлголтын үндсэн санаа нь гэмт хэрэгт бус түүнийг гарахад нөлөөлж буй хүчин зүйлсэд анхаарал хандуулахыг чухалчилдаг. Хэрвээ цагдаагийн алба хаагчид гэмт хэрэг яагаад гарч байгаа учир шалтгааныг олж чадвал тэдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлж, улмаар гэмт хэргийг таслан зогсооно. Удирдлагууд цагдаагийн алба хаагчдад асуудлыг шийдвэрлэх ур чадварыг эзэмшсэн байх шаардлага тавьдаг.

Дээр дурдсан цагдаагийн стратегиудын тодорхойлолтууд бол маш богино бөгөөд ерөнхий. Түүнээс гадна, цагдаагийн үйл ажиллагааны инновацитай холбоотой судалгаа ерөнхийдөө маш ховор тул дээрх стратегиуд яг хэр үр дүнтэй болохыг хараахан батлаагүй байгаа. Биет бус зүйлийг хэмжих нь угаасаа хүндрэлтэй байдаг тул ямар хэмжээнд яаж мэдээлэл цуглуулж, инновацийн үйл явцад дүн шинжилгээ хийх арга зүйн тодорхойгүй билээ. Ерөнхийдөө бол цагдаагийн үйл ажиллагааны инновацийг бүрэн гүйцэд судлаагүй байгаа учраас дөнгөж эхлэлийн шатанд төдий гэж үзэж болох юм.

Харин нөгөө талаас цагдаагийн технологийн инновацийг хэмжих болон дүгнэхэд амар. Түүнчлэн, технологийн инноваци гэдэг зүйл, тухайлбал шинэ тоног төхөөрөмж бүтээх, аль эсхүл зохиох нь хууль сахиулагчдыг гэмт хэрэгтэй тэмцэх шинэ стратеги боловсруулахад хүргэдэг. Өөрөөр хэлбэл, цагдаагийн газрууд өөрсдийн техникийн нөөц бололцоо нь дээр тулгуурлан өдөр тутмынхаа үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг. Үүн дээр жишээ авбал цагдаагийн алба хаагчид өөрсдийн үйл ажиллагаанд

тусгай ухаалаг утас ашиглаж эхэлснээр түүнд тааруулан шинэ арга барил боловсруулах учиртай. Энэ нь чухам технологийн болон үйл ажиллагааны инноваци хоорондоо нягт холбоотой байдаг гэсэн үг. Гэхдээ, технологийн инноваци байхгүй тохиолдолд үйл ажиллагааны инноваци гэж зүйл байх боломжгүй. Цэвэр гүн ухааны хүрээнд тайлбарлавал эд материал анхдагч байх учиртай.

Энд гэхдээ нэг зүйлийг тодруулах шаардлагатай. Технологийн инновацийг хууль сахиулагчид заавал өөрсдөө хийх шаардлагагүй. Учир нь хууль сахиулах салбараас гадна байгаа инновацийн шийдлийг алба хаагчид нутагшуулах, шилжүүлэх болон нэвтрүүлэх замаар өөрсдийн хэмжээнд хэрэглээ болгож болно. Хэрвээ технологийн инноваци нь үйл ажиллагааны инновацийг бий болгодог гэсэн таамаглал нь үнэн юм бол “яагаад Монгол шиг улс орнуудад үйл ажиллагааны инноваци байдаг юм бэ? Өөрөөр хэлбэл тэд технологийн инноваци маш бага хэмжээнд гаргадаг хэр нь яагаад үйл ажиллагааны инноваци хийгээд байдаг билээ?” гэдэг асуулыг тавих хэрэгтэй. Энэ асуулын хариу маш энгийн. Тэд үйл ажиллагааны инновацийг технологи дамжуулснаар хийх боломжтой. Монгол Улс дахь одоогийн хууль сахиулах салбар голдуу шинэ технологийг гадаадаас импортлодог. Иймээс Монгол Улс бусдаас үргэлж нэг алхмын хойно байна гэсэн үг.

Энд бас нэг зүйлийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Тэр нь юу вэ гэхээр бүх инноваци эерэг үр дүнтэй байна гэж байхгүй. Өнөөдөр хүн төрөлхтөн технологиос улам их хамааралтай болсноор нийгмийн харилцаанд сөрөг гаж нөлөө үзүүлж байгаа. Жишээ нь хэдийгээр алба хаагчид автомашинтай хол газрыг богино хугацаанд туулах боломжтой ч, яг үйлчилгээ үзүүлж буй ард иргэдтэй харилцаж, танилцах, тэдний бодит нөхцөл байдлыг мэдэх боломж олгодоггүй. Үүний адил цагдаагийн талаар интернет ашиглан мэдээлэл өгч, дэлгэцийн цаанаас олон нийттэй харилцах нь бодит амьдрал дээр харилцаж ажиллахаас тэс ондоо. Энгийнээр хэлбэл технологийн инновацийг ашиглан үйл ажиллагааны инноваци хийхдээ болгоомжтой байх хэрэгтэй. Эс бөгөөс хүсээгүй үр дүн гарах өндөр магадлалтай.

IV. Монгол дахь хууль сахиулах салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх шаардлага

Хуучин цаг үед социалист тогтолцоотой байсан улс орны хувьд Монгол Улс Америк шиг байгалийн жамаар хууль сахиулах болон батлан хамгаалах салбаруудыг цаашид хөгжүүлэх эдийн засгийн тогтвортой загвар бий болгож чадаагүй. Яг үнэндээ, 1990-ээд оноос хойш Монголын цэргийн аж үйлдвэрийн цогцолбор зогсонги байдалд орсон бөгөөд ЗХУ бутарснаар Монгол Улс бусад социалист улс орнуудын адил эдийн засгийн хямралд орсон. Өөрөөр хэлбэл тэр үед бүх зүйл нуран унасан. “Зөвлөлт холбоот улс задарснаар түүний бүрэлдэхүүн улс орнуудын нутаг дэвсгэр дээр байрлаж байсан цэргийн аж үйлдвэрийн цогцолборын аж ахуйн нэгжүүдийн хооронд дахь эдийн засгийн харилцаа холбоо тасарсан. Энэ нь эдийн засгийн бусад бүх салбарт асар том асуудлыг бий болгож, шинээр тусгаар тогтносон улс орнуудад эдийн засгийн үйл ажиллагаагаа тогтвортой барьж үлдэхэд тодорхой хэмжээний хүндрэлүүдийг учруулсан”¹⁰. Энэ нь чухам төр болон аж ахуйн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа бүр мөсөн тасарсныг хэлж байгаа юм. Чухам тэр үеэс хойш Монголын цэргийн аж үйлдвэрийн цогцолбор эдийн засгийн шилжилтийн үед тасарсан холбоосуудыг дахин бэхжүүлэх гэж маш удаан ажиллаж байна.

Хэдийгээр Монгол Улсын батлан хамгаалах төсөв жил бүр тогтвортой өсөж байгаа боловч, энэ дүнг түүний ДНБ-д шилжүүлбэл унаж байна (доорх графикийг харна уу). Түүнээс гадна, урд өмнө хэлсэнчлэн Монголын хувийн аюулгүй байдлын салбар маш буурай хөгжилтэй билээ. Хэдийгээр гэрээт харуул хамгаалалтын компаниуд Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг боловч¹¹; яг цэрэг болон хууль сахиулах байгууллагуудад зориулж шинэ технологийн инноваци бий болгодог дотоодын компани Монголд байхгүй (мэдээлэл байхгүй).




График 1. Монголын батлан хамгаалах төсөв (2001 – 2012)¹²

Үүнээс чухам, Монголын засгийн газрын зүгээс үндэсний инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилготой боловсруулсан бодлого болон шийдвэр үндэсний аюулгүй байдлыг цаашид хангахад маш сайшаалтай бөгөөд цаг үеэ олсон хэрэг болж таарч байна. Ерөнхийдөө бол орчин цаг үед одоогийн Монгол Улсад нүүрлэж буй эдийн засгийн хямрал маш том асуудал болж байгаа бөгөөд бүх салбарын хэмжээнд техник мэргэжилтнүүдийн мэдлэг болон хүчин чармайлт Монголыг Хятадаас хэт хамааралтай байгаа байдлаас гаргахад чухал ач холбогдол үзүүлнэ. Одоогийн байдлаар Монгол Улс үндэсний хэмжээнд өөрийн хувь заяаг өөрчлөх чухал өөрчлөлтийг хийх гэж оролдож байна.

Монголын эрүүгийн эрх зүйн системийг цаашид илүү үр дүнтэй болгохын тулд төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлсэн тогтвортой загварыг боловсруулах нь хамгийн эхний бөгөөд чухал алхам билээ. Барууны жишгээр Монголын цэргийн болон аюулгүй байдлын салбар хувийн компаниудыг гэрээгээр ажиллуулж, судалгаа-боловсруулалтын ажил хийлгэх бүрэн боломжтой. Хэдийгээр Монголын цэрэг болон хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд тэдгээрийн бүрэлдэхүүн болсон төрийн өмчит судалгаа, шинжилгээний байгууллагууд байгаа боловч, тэдгээр нь хүний нөөц болон санхүүжилтийн хувьд тодорхой асуудлуудтай тулгарсаар.

Бусад социалист орнуудтай адил замыг туулсан тул Монголын цэргийн аж үйлдвэрийн цогцолбор төрөл бүрийн нарийн асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй бөгөөд энэ нь 1990-ээд оноос хойш үргэлжилж буй эдийн засгийн шилжилттэй холбоотой. Энэ бүх асуудлыг дан ганц төр засаг зохицуулаад дийлэхгүй. Хувийн хэвшил орчин цаг үед нийгэмд улам үр нөлөөтэй

¹⁰ Гидадхубли Р.Г (2003): “Цэргийн аж үйлдвэрийн цогцолборыг дахин сэргээх” (*Economic and Political Weekly*, 38 дугаар дэвтэр, Дугаар 34; 3547 тал; Дараах хаягаас харах боломжтой: <http://www.jstor.org/stable/4413933> [2017 оны 2 дугаар сарын 6])

¹¹ Лхагвамаа Г. & Ли Ж.Л. (2016): “Монголын хувийн аюулгүй байдлын аж үйлдвэрийн өнөөгийн байдал” (*Advances in Social Science Research Journal*, 03 дугаар дэвтэр, Дугаар 11; 214 – 222 тал; Дараах хаягаас харах боломжтой: http://psm.du.edu/media/documents/reports_and_stats/journal_articles/reports_journal_author_lkhagvamaa_private-security-mongolia.pdf [2017 оны 2 дугаар сарын 6])

¹² SIPRI.org (2015): “SIPRI-гийн батлан хамгаалах төсвийн мэдээллийн сан” (Дараах хаягаас харах боломжтой: <https://www.sipri.org/databases/milex> [2017 оны 2 дугаар сарын 6])



МОНГОЛЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УЛСЫН
УНДСАН
ХАМГААЛАХ
ТӨСӨВ



болж байгаа учраас тэд Монголын үндэсний аюулгүй байдлыг хангахад өөрийн үүргийг ухамсарлах нь зүйтэй. Нийгэм дахь хүчний тэнцвэр гэдэг зүйл нийгмийн оролцогчдын хоорондын нарийн харилцаа холбоо нь дээр тогтож байдаг бөгөөд социалист цаг үеэс хойш энэ тэнцвэр төсөөлшгүй хэмжээнд өөрчлөгдсөн. Үүнд Монгол аль болох түргэн дасан зохицох шаардлагатай.

Хууль сахиулах салбарын инновацийг хоёр төрөлд хуваан авч үзвэл, эхний төрлийг технологийн инноваци, хоёр дахь төрлийг үйл ажиллагааны инноваци гэх бөгөөд хууль сахиулах салбарын удирдлагууд технологийн инноваци тун асуудалтай байгаа гэдгийг ухамсарлах шаардлагатай. Үүний учир нь материаллаг үзлээр технологийн инноваци үйл ажиллагааны инновацийг бий болгодог юм. Монгол Улсын хувьд хууль сахиулах болон батлан хамгаалах салбарын технологийн инновацийн түвшин маш бага учраас бид бусад улс орнуудаас шинэ технологи дамжуулах хүртэл хүлээх том бэрхшээл бий. Тодорхой нөхцөл байдалд шинэ технологи дамжуулах асуудал асар их хугацаа шаардахыг үгүйсгэх боломжгүй, ялангуяа эдгээр салбаруудын хэмжээнд.

Дэлхийн инновацийн индексээр Монгол Улс 128 улсаас 55-д жагсдаг¹³. Гэхдээ, энэ индексийг гаргахад ашигласан хувьсагчид бол ерөнхий бизнесийн орчин, эрх зүйн орчин, хүн ам зүйн мэдээлэл болон нийгмийн нөхцөл байдлыг улсын бүрийн түвшинд авч үзсэн. Хамгийн гол нь хувийн аюулгүй байдал болон батлан хамгаалах салбаруудыг тоотой хэдэн судлаачид л одоогоор судалж байгаа билээ. Түүнчлэн, цагдаагийн инноваци гэдэг зүйл өөрөө харьцангуй шинэ ойлголт тул түүнийг судалсан тохиолдол тун ховор юм (Америкт хүртэл). “Сүүлийн 40 жилийн туршид Америкийн цагдаагийн удирдлагууд ‘том шинэчлэлтүүд’ хийхэд нээлттэй хандаж байгаа боловч, яг инновацийн тухай ойлголт, учир шалтгаан, үйл явц болон үр дагаврыг судалж байгаа явдал ердөө эхлэлийн түвшинд төдий”¹⁴.

Тиймээс, Монгол Улсын хууль сахиулах салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх нь маш чухал сэдэв, ялангуяа хүний амьдрал

технологоос улам хамааралтай болж байгаа энэ цаг үед. Хэрвээ хууль сахиулагчид болон цэргийн албан тушаалтнууд цаашид улам үр дүнтэй гэмт хэрэгтэй тэмцэж, Монголын үндэсний аюулгүй байдлыг хамгаалах гэвэл аюулгүй байдлын үйлдвэрлэлийг хувьд гаргах зайлшгүй хэрэгтэй. Гэхдээ хувьд гаргана гэдэг нь хуучны төрийн өмчит үйлдвэрүүдийг татан буулгаж аль эсхүл хэн нэгний эрх мэдэлд шилжүүлэх бус тэдгээрийг дотоодын хувийн компаниудтай хамтран ажиллах тогтвортой түншлэлийг бий болгохыг хэлж байгаа гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Энгийнээр хэлбэл зарим төрлийн тодорхой үйлчилгээг дотоодын компаниудад гэрээгээр даатгуулах нь хууль сахиулах болон батлан хамгаалах салбарт гаргах инновацийн хэмжээг асар их хэмжээгээр нэмэгдүүлэх юм. Гэхдээ, энэ бол зоосны ердөө нэг тал. Аюулгүй байдлын салбарыг хувьчлахаас өмнө олон нийтийн чиг хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай. Өнөөдрийн байдлаар энэ чиглэлээр хийсэн судалгааны ажил ховор учраас үүнийг хийх учир шалтгааныг ойлгох хүн цөөхөн биз. Тиймээс, үүнийг харгалзан дээр дурдсан ойлголтуудыг илүү дэлгэрэнгүй судалж үзэх нь илүү тохиромжтой гэж үзэж байна. Ямартай ч, энд нэг зүйл бол тодорхой. Хэрвээ бид эдгээр асуудлыг авч хэлэлцэхгүй бол цаашид тулгарсаар л байх болно.

V. Дүгнэлт

Монгол Улсад давамгайлж буй орчин үеийн криминологийн үзэл баримтлал бол гэмт хэргийг ял шийтгэлээр тогтоон хязгаарлана гэдэг ойлголт. Иймдээ ч ихэнх хүн Монголд гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн чухал хэрэгсэл бол хууль эрх зүй болон цааз гэж үздэг. Гэвч, ийнхүү өгүүллээр бид гэмт хэргийн үйл ажиллагаа технологи гэдэг зүйлээс болж өөрчлөгдөж, улмаар шинэ төрлийн гэмт хэргүүд бий болж байдаг болохыг олж мэдлээ. Үүний зэрэгцээ, шинэ төрлийн гэмт хэргүүд илүү түгээмэл болж эхэлснээр хууль сахиулах салбар түүнд тааруулан дасан зохицох шаардлагатай.

Дасан зохицох гэдэг нь үндсэндээ хууль сахиулах байгууллагууд өөрсдийн гэмт хэргийг таслан зогсоох болон түүнээс урьдчилан сэргийлэх ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд дотоодын хэмжээнд өөрчлөлт хийх аль эсхүл шинэчлэл хийхийг хэлнэ. Үүнийг бид чухам хууль сахиулах салбар дахь инноваци гэж ойлгож байна. Гэхдээ, хууль сахиулах салбарын инноваци гэдэг ойлголт нь хоёр төрөлтэй. Эхний

¹³ GlobalInnovationIndex.org (2016): “Дүн шинжилгээ” (Дараах хаягаас харах боломжтой: <https://www.globalinnovationindex.org/analysis-indicator> [2017 оны 2 дугаар сарын 6])

¹⁴ Жеймс Ж.Уиллис (2011): “Цагдаагийн инноваци: Утга учир, бүтэц болон үйл явц” (Annual Review of Law and Social Science, Дараах хаягаас харах боломжтой: https://www.researchgate.net/publication/278025786_Innovations_in_Policing_Meanings_Structures_and_Processes [2017 оны 2 дугаар сарын 6])

төрөл нь технологийн инноваци бол, хоёр дахь төрөл нь үйл ажиллагааных юм. Эдгээр инноваци нь мэдээж хоорондоо холбоотой. Материаллаг үзлийн хувьд авч үзвэл, эд материал анхдагч болдог учраас технологийн инноваци үйл ажиллагааны инновацийн суурь үндсийг тавьж өгдөг. Гэтэл, Монгол Улс шиг технологийн инноваци харьцангуй бага байдаг улс орнуудад чухам яагаад үйл ажиллагааны инноваци байдаг вэ гэхээр бусад улс орнуудаас технологи дамжуулдагтай холбоотой юм (импортолдог). Харамсалтай нь тодорхой нөхцөл байдалд ингэж ажиллах нь хэтэрхий удаан байх сөрөг талтай.

Түүнээс гадна, хууль сахиулах салбар өөрөө маш олон төрлийн шинжлэх ухааны мэдлэгийг хамруулсан ойлголт учраас тэдгээр салбар ухаануудтай холбоотой техникийн мэдлэг зайлшгүй шаардлагатай. Өнөөгийн инновацийн дэд бүтцийн хөгжилд тулгамдаж буй асуудлууд ерөнхийдөө хууль сахиулах салбар дахь хөрөнгө оруулалт болон техникийн мэргэжилтнүүд дутмаг байдагтай холбоотой. Хэрвээ бид Америк улсын туршлагыг эдийн засаг болон аж үйлдвэрийн салбарын хувьд авч үзэж, дүгнэвэл тэдний хууль сахиулах болон батлан хамгаалах салбарын бүтэц, зохион байгуулалт маш үр дүнтэй бөгөөд төр болон хувийн хэвшил хоёр нягт хамтран ажилладаг нь тодорхой. Монгол Улсын хувьд хувийн аюулгүй байдлын үйлдвэрлэл тун хоцрогдсон бөгөөд цэргийн аж үйлдвэрийн цогцолбор нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээл руу шилжихэд одоог хүртэл асуудалтай тулгарч, шинэчлэгдэж чадаагүй байна.

Аз болоход, Монголын засгийн газар үүнийг өөрчлөхөөр зүтгэж байна. Гэхдээ тэдний хийсэн ажил одоогоор амжилтгүй явсаар. Гол учир шалтгаан нь олон нийтийн зүгээс хуучны чиг хандлагыг баримталж, өмнөх системээс салж өгөхгүй байгаа тул үйл явцыг удаашруулсаар байна. Түүнээс гадна, яг энэ өгүүлэлд дурдсан сэдвүүдийг судалсан ажил бараг байхгүй. Тиймээс, хэрвээ Монгол Улс өөрсдийгөө энэ байдлаас гаргахыг хүсвэл дээр дурдсан сэдвүүдийг судалж үзэх нь зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл Монголын хууль сахиулагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлж, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал бол дан ганц хууль эрх зүйн зохицуулалт болон тогтоомжид байдаггүй гэдгийг ухамсарлах хэрэгтэй. Тэд шинэ техник технологийг дамжуулж, нэвтрүүлэх нь зөвхөн чухал

биш, түүнийг бүтээх нь мөн чухал гэдгийг сайтар ойлгох ёстой. Өөрсдийн судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох цаг нэгэнт болжээ.

VI. Эх сурвалжийн жагсаалт

1. Роналд Л.Акерс & Кристин С.Селлерс (2009): “Криминологийн онол” (Oxford University Press – 5 дахь хэвлэл; 123 – 148 тал)
2. Стивен Д’Алфонсо (04.09.2014): “Яагаад зохион байгуулалттай гэмт хэрэг болон алан хядах бүлгэмүүдийн тоо ихсэж байна вэ?” (Security Intelligence; <https://securityintelligence.com/why-organized-crime-and-terror-groups-are-converging/> [2017 оны 2 дугаар сарын 6])
3. Майкль Аарон Деннис (Сүүлд шинэчилсэн: 08.08.2016): “Кибер гэмт хэргийн тодорхойлолт” (Britannica Encyclopedia; Дараах хаягаас харах боломжтой: <https://www.britannica.com/topic/cyber-crime> [2017 оны 2 дугаар сарын 6])
4. Элдон Аморосо (2016): “Кибер аюулгүй байдал: Цагдаагийн удирдлагын зүгээс анхаарах хэрэгтэй асуудлууд болон авах хариу арга хэмжээ” (The Police Chief Magazine – 2016 оны 10 сар; 28 – 33 тал)
5. “Хууль сахиулах үйл ажиллагаа (2016): Онол, практикийн тулгамдсан асуудал”. (Хууль сахиулахын их сургууль; Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Боть 2; 475 дахь тал.
6. Эйшли Керк (27.10.2015): “Дэлхийн хамгийн том батлан хамгаалах төсөвтэй улсууд юу вэ?” (The Telegraph; <http://www.telegraph.co.uk/news/uknews/defence/11936179/What-are-the-biggest-defence-budgets-in-the-world.html> [2017 оны 2 дугаар сарын 6])
7. П.В.Сингеп (2005): “Дайныг ацаглах” (Foreign Relations, 84 дүгээр дэвтэр, Дугаар 2; 120 тал; Дараах хаягаас харах боломжтой: <http://www.jstor.org/stable/20034280> [2017 оны 2 дугаар сарын 6])
8. Чарльз Неметь (2011): “Хувийн аюулгүй байдлын салбар болон хууль эрх зүй” (Elsevier; 4 дахь хэвлэл ; 8 – 9 тал)
9. BurglarAlarms.org (2010): “Дохиоллын системийн түүх” (Дараах хаягаас харах боломжтой: <http://www.burglaralarms.org/the-history-of-burglar-alarms/> [2017 оны 2 дугаар сарын 6])
10. Гидадхубли Р.Г (2003): “Цэргийн аж үйлдвэрийн цогцолборыг дахин сэргээх” (Economic and Political Weekly, 38 дугаар дэвтэр, Дугаар 34; 3547 тал; Дараах хаягаас



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДСНИЙ
УНДСНИЙ
УНДСНИЙ

харах боломжтой: <http://www.jstor.org/stable/4413933> [2017 оны 2 дугаар сарын 6]

11. Лхагвамаа Г. & Ли Ж.Л. (2016): “Монголын хувийн аюулгүй байдлын аж үйлдвэрийн өнөөгийн байдал” (*Advances in Social Science Research Journal*, 03 дугаар дэвтэр, Дугаар 11; 214 – 222 тал; Дараах хаягаас харах боломжтой: http://psm.du.edu/media/documents/reports_and_stats/journal_articles/reports_journal_author_l_lkhagvamaa_private-security-mongolia.pdf [2017 оны 2 дугаар сарын 6])

12. SIPRI.org (2015): “SIPRI-гийн батлан хамгаалах төсвийн мэдээллийн сан” (Дараах хаягаас харах боломжтой: <https://www.sipri.org/databases/milex> [2017 оны 2 дугаар сарын 6])

13. GlobalInnovationIndex.org (2016): “Дүн шинжилгээ” (Дараах хаягаас харах боломжтой: <https://www.globalinnovationindex.org/analysis-indicator> [2017 оны 2 дугаар сарын 6])

14. Жеймс Ж.Уиллис (2011): “Цагдаагийн инноваци: Утга учир, бүтэц болон үйл явц” (*Annual Review of Law and Social Science*, Дараах хаягаас харах боломжтой: https://www.researchgate.net/publication/278025786_Innovations_in_Policing_Meanings_Structures_and_Processes [2017 оны 2 дугаар сарын 6])